БАТЛАВ
ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ө.БАТ-АМГАЛАН

2025 оны 04 дүгээр сарын ....-ны өдөр

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ДЭМЖЛЭГ, ТУСЛАЛЦАА ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ӨРХ, ИРГЭНИЙГ НИЙГЭМШҮҮЛЭХ, ХАМТ ОЛНЫ БҮЛЭГ БҮРДҮҮЛЭХ, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРТЭЙ БОЛГОХ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АМЬДРАХ УХААНД СУРГАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ /БАГЦ-2/

Сүхбаатар аймаг

Ерөнхий зүйл.

Энэ техникийн тодорхойлолт нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.5, 18.1.9-д заасан үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай техникийн үзүүлэлтийг тусгасан болно.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээнд багтана.

- 18.1.1. Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах сургалт зохион байгуулах
- 18.1.2. Зөвөлгөө өгөх үйлчилгээ
- 18.1.5. Өдрийн үйлчилгээнд хамруулах
- 18.1.9. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах.

Ажлын цар хүрээ.

Уг нь үйлчилгээ нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/35 дугаар тушаал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/53 дугаар тушаалаар үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам, аргачилалын дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасны дагуу зорилтот бүлгийн иргэдэд үйлчилгээг үзүүлнэ.

Тавигдах шаардлага:

| № | Нэр, төрөл | Тавигдах шаардлага |
|---|---|---|
| 1 | Хүний нөөц | -Мэргэжлийн нийгмийн ажилтан /гэрээт-1/ |

| | | |
|---|---|---|
| | | -Чиглүүлэгч ажилтан 1<br>-Багш /гэрээт-1/ |
| 2 | Ерөнхий шаардлага | -Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бол хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх /Сүхбаатар аймгийн нутаг байршилтай, харьяалалтай байх/<br>-Үйчилгээ үзүүлж буй байр тогтмол байршилтай байх<br>-Үйлчилгээ үзүүлэх эсвэл мэргэшсэн боловсон хүчинтэй байх<br>-Боловсон хүчний мэргэжлийн дипломтой байх<br>-Ажлын байрны тодорхойлолттой байх<br>-Чиглэл, зорилго, хүрэх үр дүнгийн талаарх мэдээллийг агуулсан 7 хоногийн сургалтын хөтөлбөртэй байх<br>-Ажил үүргийн хуваарьтай байх<br>-Үйлчилгээг үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх<br>-Архи,мансуурах донтой, сэтгэц, сүрьеэ зэрэг халдварт өвчтэй хүн ажилуулахгүй байх<br>-Сүүлийн 1 жилийн үйл ажиллагааны тайлантай байх |
| 3 | Техникийн чадавхи болон туршлагын шаардлага | -Өөрийн өмчийн болон түрээсийн байртай байх<br>-Сургалт явуулах тоног төхөөрөмжтэй байх /компьютер, проектер, дэлгэц/<br>-Байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх<br>-Ганцаарчилсан зөвөлгөө өгөх өрөөтэй байх |

| | | |
|---|---|---|
| | | -Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх<br>-Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлэх<br>- профайлинг үнэлгээ хийх /чадварыг тодорхойлох/<br>-Өрхийн гишүүн бүрт өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах<br>-Өрхийн нөөц боломжид тохирсон бүлгийн төсөл боловсруулах |

**Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээний үнэ тариф /Багц-2/**

| № | Ажилтан | Тоо | Үйлчлүүлэгчийн тоо /хамгийн багадаа/ | Нийт ажиллах сар | Сарын цалин, урамшуулал /төгрөгөөр/ | Жилийн нийт зардал /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэргэжлийн нийгмийн ажилтан /гэрээгээр/ | 1 | 50 | 5 | 1,500,000 | 7,500,000 |
| 2 | Чиглүүлэгч ажилтан | 1 | 50 | 5 | 1,200,000 | 6,000,000 |
| 3 | Багш /гэрээт/ | 0,5 | 50 | 5 | 750,000 | 3,750,000 |
| 4 | Үйл ажиллагааны зардал, усанд оруулах /үйлчлүүлэгчийн халуун усны газрын төлбөрийн 50 хувийг төлөх/, хувийн ариун цэвэр сахиулах, хичээлийн хэрэглэгдэхүүнд /нийт зардлын 20 хувиар тооцох/ | | | | | 3,975,000 |
| Нийт | | | | | | 21,225,000 |

**Тайлбар:** Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд олгох бүлгийн төслийн санхүүжилт. Нийт хамрагдах өрх 33, нэг өрхөд 1,800,000 нийт 59,400,000 төгрөг олгогдоно. Энэ 33 өрхийг нийт 50 өрхөөс сонгож санхүүжүүлнэ.

| № | Ажилтан | Тоо | Үйлчлүүлэгчийн тоо /хамгийн багадаа/ | Нийт ажиллах сар | Сарын цалин, урамшуулал /төгрөгөөр/ | Жилийн нийт зардал /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Бүлгийн төслийн санхүүжилт /өрхөд олгох/ | | 33 өрхөд | 5 | 1,800,000 | 59,400,000 |

| | |
|---|---|
| Нийт | 59,400,000 |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧИГ Б.ЭНХНАРАН